

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Арилжаа хотлогч

Арилжааны үед арилжааны дэгийг мөрдүүлэх, арилжааг нээх, хаах, түр зогсоох эрх бүхий биржийн ажилтан

Арилжаанд оролцогч

Биржид бараа, түүхий эд арилжаалах зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд оролцох зөвшөөрөлтэй, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, биржийн арилжааны зуучлагч (брокер), тэдгээрийн харилцагч

Арилжааны зах зээлд оролцогч

Бараа, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, чанар, тоо хэмжээг тодорхойлох, хадгалах, тээвэрлэх, зуучлан арилжаалах, биржийн арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, гарал үүслийг гэрчлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээд

Арилжааны мэдээ

Биржээр арилжаалсан гэрээний үнэ, тоо хэмжээ зэрэг шаардлагатай үзүүлэлт бүхий нийтэд зориулсан мэдээлэл

Арилжааны эрх

Биржийн гишүүний арилжаанд оролцох эрх

Бирж

Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК (Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани)

Биржийн байнгын бус гишүүн

Биржтэй байнгын бус гишүүний гэрээ байгуулсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч “хоршоо”

Биржийн байнгын гишүүн

Биржийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн шаардлагыг хангасан хуулийн этгээд

Биржийн гүйцэтгэх удирдлага

Эрх бүхий байгууллагаас томилогдсон биржийн удирдах албан тушаалтан

Биржээр арилжаалах жагсаалт

Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар хариуцсан Засгийн Газрын гишүүний баталсан Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн жагсаалт

Гишүүнчлэлийн гэрээ

Биржийн байнгын болон байнгын бус гишүүний шалгуур үзүүлэлтийг хангасан этгээд болон биржийн хооронд үүсэх харилцааг нарийвчлан зохицуулах гэрээ

Гэрээний тодорхойлолт

Биржээр арилжаалах бараа, түүхий эдийг арилжаалах урьдчилан тогтоосон нөхцөл

Дэнчин

Арилжааны эрсдлээс хамгаалах барьцаа хөрөнгө

Баталгаат дэнчин

Биржийн гишүүн захиалгын дүнгээс үл хамааран арилжаа эхлэхээс өмнө заавал байршуулах дэнчин

Анхдагч дэнчин

Арилжаанд оролцогч нь биелсэн хэлцлийн үүргээ биелүүлэх баталгаа болгон байршуулах дэнчин

Тогтворт дэнчин

Анхдагч дэнчингийн заавал байлгах доод хязгаарыг тодорхойлох дэнчин

Хүргэлтийн дэнчин

Арилжаанд оролцогч барааг биетээр хүргэх тохиолдолд биржийн гэрээний талууд хүргэлт хийх, хүлээн авах баталгааг илэрхийлэх дэнчин

Зах зээл үүсгэх эрх

Нэг гэрээний хувьд авах, зарах саналыг зэрэг оруулах эрх

Захиалга	Арилжаанд оролцогчийн цахим арилжааны системд оруулж буй авах/зарах үнэ, хэмжээг тодорхойлсон санал
Зах зээлийн захиалга	Арилжаандоролцогч тусгайлсан үнийн санал өгөхгүй бөгөөд биржээр тогтсон үнээр гэрээ арилжаалах санал
Нохцолт захиалга	Арилжаандоролцогч авах захиалгын хувьд зөвшөөрч болох/ дээд үнэ, зарах захиалгын хувьд зөвшөөрч болох доод үнийн саналыг тогтоож гэрээ арилжаалах санал
Кросс захиалга	Арилжаандоролцогчид урьдчилан тохирсон нөхцөлөөр авах/зарах захиалгаар хоорондоо хэлцэл гүйцэтгэх санал
Зах зээл үүсгэгчийн захиалга	Арилжаанд оролцогч биржээс зөвшөөрсөн үнийн зөрүү бүхий авах, зарах саналыг зэрэг оруулах санал
Итгэмжлэгдсэн этгээд	Биржийн итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж, биржтэй гэрээ байгуулсан хуулийн этгээд
Шалгуур үзүүлэлт	Биржээсбаталсан арилжааны зах зээлд оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт
Итгэмжлэл хүсэгч	Биржийн холбогдох журмын дагуу агуулах, тээвэрлэгчийн үйл ажиллагаа явуулах зорилгоор биржээс итгэмжлэл хүсэгч этгээд
Клиринг, төлбөр тооцооны нэгж	Биржээр арилжаалсан гэрээний клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэх эрх бүхий нэгж
Клирингийн үйлчилгээ	Хэлцэл биелснээс хойш төлбөр тооцоо гүйцэтгэх хүртэл зохионбайгуулах үйл ажиллагааг бие даан зохион байгуулах эрх
Клирингийн эрх	Хэлцэл биелснээс хойш төлбөр тооцоо гүйцэтгэх хүртэл зохионбайгуулах үйл ажиллагааг бие даан зохион байгуулах эрх
Онлайн арилжаа	Биржийн гишүүд арилжааны хуваарийн дагуу биржийн арилжааны системд зайнаас холбогдон арилжаанд оролцох хэлбэр
Гишүүнчлэлийн эрх	Биржийн байнгын гишүүний хувьд эдлэх үндсэн эрх
Спот гэрээ	Бараа, түүхий эдийн хугацаагүй буюу шууд хэрэгжүүлэх гэрээ
Танхимын арилжаа	Биржийн гишүүн арилжааны хуваарийн дагуу биржийн танхимд ирж, арилжаанд биечлэн оролцох хэлбэр
Төлбөр тооцооны данс	Арилжаанд оролцогч болон харилцагчийн биржийн гэрээний дагуу төлөх төлбөрийг байршуулах арилжааны банкин дахь данс
Үнийн өөрчлөлтийн хязгаарлалт	Тодорхой хугацаанд үнийн өөрчлөлтөд тавих дээд, доод хязгаар
Үнийн хэлбэлзлийн нэгж	Тухайн гэрээний үнийн өөрчлөгдж болох хамгийн бага нэгж
Харилцагч	Биржийн байнгын гишүүнд бүртгүүлж, бирж дээр данс нээлгэсэн этгээд
Хэлцэл	Биржийн арилжааны системд бүртгэгдсэн арилжаанд оролцогчдынхооронд биржийн гэрээг авах/зарах тохиролцоо